



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№49 /493/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.03.23

Цаг үе, үйл явдал

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 340 ДҮГЭЭР АНГИД АЖИЛЛАЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ухнаагийн Хүрэлсүх Баян-Өлгий аймагт ажиллах үеэрээ Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн алба хаагчидтай уулзав. Түүнийг дагалдаж, УИХ-ын гишүүн Х.Баделхан, Т.Аубакир, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлагч бригадын генерал Б.Баатар, БИЦУГ-ын дарга хурандаа Х.Батсайхан нарын албаныхан ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийг тус ангийн байрлалд хүрэлцэн ирэхэд ангийн бие бүрэлдэхүүн жагсаж угтлаа. Тус анги нь Баян-Өлгий аймгийн Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвтэй хамтран хугацаат цэргийн алба хаагчдад мэргэжил олгох сургалтыг барилгын өргөн мэргэжил, хүнд машин, механизмын оператор, засварчин зэрэг чиглэлээр зохион байгуулсан байна.

Хугацаат цэргийн алба хаагчид бүтээн байгуулалтын ажилд оролцоноор мөнгөн хуримтлал үүсгэхээс гадна мэргэжил эзэмшиж халагдах давуу талтайг тус ангийн удирдлага танилцуулж байв.

Мөн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ангийн байрлалд "Ногоон төгөл" хотхон байгуулахаар төлөвлөсөн бөгөөд таван нэр төрлийн 2,150 ширхэг гоёлын болон жимсний мод, бутыг арчлан ургуулж байгааг ангийн захирагч, хурандаа У.Буянжаргал хэллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн бие бүрэлдэхүүнд хандан хэлсэн үгийнхээ эхэнд Монгол Улсын Ерөнхийлөгч "Монгол цэргийн өдөр", орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлэв.

Сүүлийн жилүүдэд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин бүтээн байгуулалтын үйлсэд манлайлан оролцож байгаа бөгөөд Барилга-инженерийн 340 дүгээр анги нь байгуулагдаад удаагүй ч үүрэг гүйцэтгэх чадавхаа богино хугацаанд бүрдүүлж чадсаныг Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч тэмдэглэлээ. Тухайлбал, Монгол Улсын эдийн засаг, орон нутгийн хөгжилд дорвитой дэмжлэг үзүүлэх стратегийн ач холбогдолтой "Асгат"-ын мөнгөний орд чиглэлийн зам гүүрний ажлыг богино хугацаанд, чанарын өндөр түвшинд

хийж гүйцэтгэсэн нь улс орны бүтээн байгуулалтад төрийн цэргийн байгууллага оролцох эхлэлийг тавьж, Зэвсэгт хүчний нэр хүндийг өндөрт өргөсөн хэмээн онцлов.

Мөн монголчууд бид бие даан дэд бүтцийн том төслийг цогцоор нь гүйцэтгэж чаддаг гэдгийг батлан харуулсан "Тавантолгой-Зүүнбаян", "Зүүнбаян-Ханги" чиглэлийн төмөр замыг барьж байгуулах төслийг хэрэгжүүлэхэд оролцсоныг дурдлаа.

Энх цагийн бүтээн байгуулалтад идэвхийлэн оролцохын зэрэгцээ ангийн үндсэн үүрэг болон хуулиар хүлээсэн бусад үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, цэргийн сургалт бэлтгэлдээ нэн тэргүүнд анхаарч ажиллах хэрэгтэйг санууллаа.

Монгол Улсын Зэвсэгт хүчний шинэ зууны түүхийн хуудсыг бичилцэж буй Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн алба хаагчдын улс орноо батлан хамгаалах, бүтээн байгуулах их үйлсэд өндөр амжилт хүсэж, гэр бүлд нь эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөв.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийг тус ангид ажиллах үеэр машин, техник гардууллаа.

С.ГАНБЯМБА: БАРИЛГА ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙГ БАЙГУУЛСАН ГОЛ ҮНДЭС НЬ ТА БҮХНИЙ ОЛОЛТ, АМЖИЛТ



санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжин "Ногоон төгөл" хотхон байгуулах ажлын хүрээнд шар хуайс, хайлаас, үхрийн нүд бургас, чацарганын 2150 гаруй мод тарьж ургуулсан байна. Энэ үеэр бригадын генерал С.Ганбямба тус ангийн бие бүрэлдэхүүнтэй уулзаж Зэвсэгт хүчний бодлого, үйл ажиллагаа, өнөөгийн төлөв, цаашдын зорилго, зорилт болон салбарын хэмжээнд хийгдсэн томоохон ажлуудын талаар мэдээлэл өглөө. Тэрээр бие бүрэлдэхүүнд хандан хэлсэн үгэндээ "Анх байгуулагдсан цагаасаа хойш тус анги, хамт олон тасралтгүй



болсон. Та бүхэн аймаг орон нутаг болон өөрсдийн ангиа хөгжүүлэх талаар нэлээд ажлыг хийж хэрэгжүүлсэн байна. Бие бүрэлдэхүүний ая тухтай орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бололцоог хангах чиглэлээр хийсэн бүтээлч ажлуудтай дэлгэрэнгүй танилцлаа. Дээр нь Монгол Улсыг хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулж байгааг онцлох нь зүйтэй. Төмөр замын бүтээн байгуулалтад ажиллаж, даалгасан үүргийг маш сайн гүйцэтгэсэн. Энэ томоохон бүтээн байгуулалтууд нь улс орны эдийн засгийг тэлэхэд чухал ач холбогдолтой. Ингэснээр Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний төсөв нэмэгдэх таатай нөхцөл бүрдэнэ. Тэгэхээр энэ том ажлын ард та бүхэн амжилттай гарцгаасан" хэмээгээд тохиогоод удаагүй байгаа "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 102 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлж, ажлын амжилт, эрүүл энхийг хүсэн ерөөв.

Уулзалтын төгсгөлд Зэвсэгт хүчний 340 дүгээр ангид "HISONE" маркийн эмнэлгийн бүрэн тоноглогдсон автомашиныг гардууллаа. **Ахлах дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ**

ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба өчигдөр Зэвсэгт хүчний 340 дүгээр ангид ажиллалаа. Түүнийг дагалдаж Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлагч бригадын генерал Б.Баатар, БИЦУГ-ын дарга хурандаа Х.Батсайхан, Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Ц.Буянтогтох нарын албаныхан ажилласан юм.

Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн захирагч хурандаа У.Буянжаргал ангийн үйл ажиллагаа, дэвшүүлсэн зорилго зорилт, хийж хэрэгжүүлсэн болон цаашид төлөвлөсөн ажлуудын

талаар мэдээлэл өглөө. Тус анги нь улс орны бүтээн байгуулалтын ажил болон олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцох чиг үүрэгтэйгээр байгуулагдсан. Өнгөрсөн хугацаанд Баян-Өлгий аймаг дахь Тагнуулын газрын барилга, Асгатын мөнгөний ордын автозам, 150 ортой хүүхдийн цэцэрлэг, "Хүчирхийллийн эсрэг төв"-ийн барилга, Тавантолгой-Зүүнбаян, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам зэрэг улс орны стратегийн томоохон бүтээн байгуулалтад үүрэг гүйцэтгэжээ.

Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн



бүтээн байгуулалтын ажилд оролцсон. Энэ бол Зэвсэгт хүчинд барилга-инженерийн цэргийг байгуулсан гол зорилго юм. Өдгөө Зэвсэгт хүчин маань өргөжин тэлж, үйл ажиллагаагаа улам төгөлдөржүүлэн 5 төрлийн цэрэгтэй

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-10	-23


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
41	26

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,528	3,531
EUR	3,800	3,815
CNY	514	515
RUB	44.90	45.30
JPY	26.90	27.10
KRW	2.70	2.71

ЗУРХАЙ



ХАВРЫН ДҮНД ХӨХӨГЧИН ТУУЛАЙ САР ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Хэл, ам, хэрүүл тэмцэл ирнэ НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 06.50-19.08

Барилдлага:

Рашаан

Шүтэн барилдлага:

Нэр өнгө

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр санасан хэрэг түргэн бүтнэ. Бүтээл үйлдэх, тус чухалчлах, хэл ам дарах, башир, хатуу, түргэн үйлнээ сайн, үйл буруутгах, ламд золгох зэрэг цагаан зүгийн үйлэнд сайн. Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олодох, баруун чих хангинавал ундаа олодох, зүүн чих хангинавал түлэгдэх, нохой уливал үхсэний сураг сонсох, хэрээ дуугарвал нөхөртэй учрах, тагнай загатнавал хувцас олодох, бие татвал эцэг, эхэд муу. Хөл татвал хэрүүл, тэмцэл гарах муу ёр болой.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 682,891,877

Эдгэрсэн

Нийт: 655,824,688

Нас барсан

Нийт: 6,822,515

Цахим шууданд

ЗХЖШ-ЫН ДАРГА БРИГАДЫН ГЕНЕРАЛ С.ГАНБЯМБА ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 331 ДҮГЭЭР АНГИД АЖИЛЛАВ



ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба Зэвсэгт хүчний 340 дүгээр ангид ажилласан талаар бид мэдээлсэн. Тэгвэл бригадын генерал С.Ганбямба үргэлжлүүлэн Зэвсэгт хүчний 331 дүгээр ангид ажилласан бөгөөд Тусгай хүчний цэргийн командлагч бригадын генерал Б.Баатар, Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Ц.Буянтгогтох нар байлцав. Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн захирагч дэд хурандаа Х.Золжаргал ангийн үйл ажиллагаа, бэлэн байдал, үүрэг гүйцэтгэлт, сургалт бэлтгэл, ололт амжилт болон тулгамдсан асуудлуудын талаар танилцууллаа.

Зэвсэгт хүчинтэй хамтарсан "Уулын явган цэргийн сургалт"-ыг үе шаттай, амжилттайгаар явуулж иржээ. Мөн Зэвсэгт хүчний 2022 оны "Тэргүүний анги"-аар шалгарсан зэрэг амжилтыг үзүүлснээс гадна өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллыг сайжруулах болон тохижилт, засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн гэдгийг ангийн удирдлага онцолж байв.

Бригадын генерал С.Ганбямба хичээлийн байр, тавиулан, ногооны зоорь зэрэг барилга байгууламжтай танилцсаны дараагаар ангийн бие бүрэлдэхүүнтэй уулзав. Тэрээр хэлэхдээ "Өнгөрсөн хугацаанд өсөн дэвшиж, сургалт бэлтгэлийн хувьд улам чанаржиж, бүтээн байгуулалтын ажил ч олноор хийгдсэн гэдгийг сая харлаа. Үүнд барилга-инженерийн цэргийн ангийн үүрэг оролцоо их байгаагаас гадна тус ангийн удирдлага, хүн нэг бүрийн идэвх санаачилга, сэтгэл зүтгэл өндөр байна гэдгийг онцлох нь зүйтэй. Та бүхний гар нийлэмжтэй ажиллагааны үр дүнд өнөөдөр энэ анги ийм хэмжээнд хүрсэн. Цаашид ч ЗХЖШ-аас Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийг, бэхжүүлж хөгжүүлэхэд ихээхэн анхаарч ажиллана. Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгааг бид мэднэ. Нөхцөл байдал сайжрах үед төрийн удирдлагуудад асуудлыг хөндөж тавина" гэв. Энэ үеэр зарим алба хаагчдад албан тушаалын зэрэглэлийн цол хүртээж, төрийн одон медалиар шагнасны зэрэгцээ тус ангийн хамт олонд автомашин гардуулан өглөө.

Ахлах дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ



СПОРТЫН ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Монгол Улсаас БНСУ-ын цэргийн их дээд сургууль, коллеж, академи, дамжаанд суралцаж буй офицер, ахлагч, сонсогчид орчин цагийн Зэвсэгт хүчин байгуулагдсаны 102 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-

ийг тохиолдуулан спортын тэмцээн, уралдаан зохион байгуулжээ. Арга хэмжээнд Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайдын яамны Элчин зөвлөх Ж.Оюунбаатар, цэргийн атташе дэд хурандаа Э.Түшиг, Монгол

Цэргийн нэгдсэн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, бэлтгэл хурандаа н.Наранхүү болон БНСУ-ын цэргийн их дээд сургууль, коллеж, академи, дамжаанд суралцаж буй офицер, ахлагч, сонсогчид оролцсон байна.



МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН СУРГАЛТ, СЕМИНАР ЭХЭЛЛЭЭ



Ирэх сарын 1-ний өдрөөс эхлэн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын дунд "Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшнийг тогтоох үзлэг" гурван үе шаттайгаар зохион байгуулагдана. Үүнтэй уялдуулан тус байгууллагуудын биеийн тамир, спорт хариуцсан албан тушаалтнуудыг дадлагажуулах, туршлага солилцох, онол болон дадлагын мэдлэг олгох зорилготой мэргэжил арга зүйн сургалт, семинар Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Сургалтын төвийг түшиглэн явагдаж байна.

нээлтийн үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Ц.Тогоо, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга хурандаа Ж.Өсөхбаяр, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар нар оролцоо. Энэхүү сургалт нь "Цэргийн биеийн тамирын заах арга зүй, сургалтын нэгдсэн тогтолцоо" сэдвийн хүрээнд явагдаж буй бөгөөд сургалтад оролцож байгаа алба хаагчид хоёр өдрийн хугацаанд биеийн тамирын бэлтгэлжилтийн стандартын шалгуур үзүүлэлтийн заах арга зүй, ур чадварын талаар дадлагад чиглэсэн хичээл, семинарт хамрагдах юм.

Тус сургалт, семинарын



ТЭМҮҮЖИН ӨРЛӨГ СУРГУУЛИЙН СУРАГЧИД "АСТРОПАРК"-ААР ЗОЧИЛЛОО



1981 оны гуравдугаар сарын 22-ны өдөр Монгол хүн сансарт ниссэн өдөр. Зөвлөлт Холбоот Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын сансрын хамтарсан нислэгээр БНМАУ, ЗХУ-ын баатар, БНМАУ-ын сансрын нисэгч Жүгдэрдэмидийн Гүррагчаа, ЗХУ-ын хошой баатар, БНМАУ-ын баатар, ЗХУ-ын сансрын нисэгч Владимир Александрович Жанибеков нарын бүрэлдэхүүнтэй хамтарсан баг "Союз-39" хөлгөөр сансарт хөөрч, гуравдугаар сарын 30-ны 19:42 цагт эх дэлхийдээ амжилттай газардсан түүхтэй.

8 дугаар ангийн сурагчид Сансар, од, эрхсийн ордон буюу "Астропарк"-аар зочилж сансрын нисэгч Ж.Гүррагчаа, Владимир Александрович Жанибеков нарын өмсөж байсан хувцас хэрэглэл, "Союз-39" хөлгийн буугч аппарат зэрэгтэй танилцаж сансрын нислэгийн түүхтэй холбоотой мэдээ мэдээллийг авсан юм.

Тэгвэл уг түүхэн өдрийг тохиолдуулан өчигдөр ҮБХИС-ийн харьяа Тэмүүжин Өрлөг сургуулийн 7,

Мөн сурагчид арга хэмжээний төгсгөлд "планетарит" орж өдрийн цагаар одод тэнгэрийг харж Алтангадас, Долоон бурхан зэрэг оддын байршлыг мэдэж авсны зэрэгцээ сар хэрхэн үүссэн талаарх богино хэмжээний видео контентыг үзэж сонирхлоо.